7.5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршинсуугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ	1	тийм	тийм	
7.6. Түүх соёлын дурсгалт эд зүйлийгнүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	-	үгүй	үгүй	
7.7. Байгаль орчны менежментийн удирдлага зохион байгуулалтын аргахэмжээ	-	тийм	тийм	

11. Байгууллагын хариуцлагын даатгалын хуулбар

Манай компани нь Монгол тунжөн майнинг инвестмент групп ХХК-иас ажиллах хүчний гэрээ хийж ажилласан. Мөн Бод Даатгал ХХК хариуцлагын гэрээ байгуулсан.

**АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ**

ЭНЭХҮҮ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ (цаашид “Гэрээ” гэх)-г 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдөр:

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 01 дүгээр хороо, 05 дугаар хороолол, Энхтайваны өргөн чөлөө гудамж, Эко интернэйшнл тауэр барилга, 15 давхар, зүүн жигүүр хаягт бүртгэлтэй, Монгол улсын хуулийн дагуу байгуулагдсан “Монголын токен майнинг инвестмент групп корпорэйшн” ГХО ХХК (Улсын бүртгэлийн дугаар: 9019097680, Регистрийн дугаар: 6438776)-г төлөөлөн Гүйцэтгэх захирал албан тушаалтай Хятад улсын иргэн LUO XIAOYONG (цаашид “Захивалагч” гэх);

-болон-

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 01 дүгээр хороо, 05 дугаар хороолол, Энхтайваны өргөн чөлөө гудамж, Эко интернэйшнл тауэр барилга, 15 давхар 1501 тоот хаягт бүртгэлтэй, “Монгол тунжон майнинг инвестмент групп” ГХО ХХК (Улсын бүртгэлийн дугаар: 9019090126, Регистрийн дугаар: 6454763)-г төлөөлөн Гүйцэтгэх захирал албан тушаалтай Хятад улсын иргэн LUO DAN (цаашид “Гүйцэтгэгч”) нар Монгол Улсын Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Компанийн хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг үндэслэн, харилцан тохиролцож дараах нөхцөлөөр энэхүү гэрээг байгуулав.

Захивалагч болон Гүйцэтгэгчийг хамтад нь “Талууд” гэх бөгөөд тус бүрд нь “Тал” гэнэ.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь Захивалагчийн захиалгын дагуу гэрээнд заасан ажлын байранд өөрийн ажилтныг гэрээнд заасан хугацаанд ажиллуулах буюу ажиллах хүчний үйлчилгээ үзүүлэх, Захивалагч үйлчилгээний төлбөрийг төлөхтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2. Гүйцэтгэгчийн ажилтан гэрээнд заасан ажил, үйлчилгээг Захивалагчийн Хөдөлмөрийн дотоод журамд заасан ажлын цагийн хуваарь, давтамжийн дагуу гүйцэтгэн ажиллах ба Захивалагчийн холбогдох нэгжийн удирдлага доор ажиллана.

ХОЁР. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ

- 2.1. Гүйцэтгэгч нь энэхүү Гэрээ хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд Захивалагчийн доор дурдсан ажлын байранд өөрийн ажилтнаа ажиллуулна. Үүнд:
 - 2.1.1. Геологич, Тусгай зөвшөөрөл хариуцсан багийн ахлах
 - 2.1.2. Геологич
 - 2.1.3. Төлөвлөлтийн инженер
 - 2.1.4. Тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн
 - 2.1.5. Дата геологич
 - 2.1.6. ХАБЭА-н мэргэжилтэн
 - 2.1.7. Байгаль орчны мэргэжилтэн
 - 2.1.8. Нягтлан бодогч
 - 2.1.9. Хүний нөөцийн ажилтан
 - 2.1.10. Кемп хариуцсан ажилтан
 - 2.1.11. Захиргааны ажилтан
 - 2.1.12. Орчуулагч, туслах

- 2.2. Гүйцэтгэгч нь гэрээт ажил үйлчилгээг зохих мэргэжлийн, туршлага, ур чадвартай ажилтнаар гүйцэтгүүлнэ.
- 2.3. Гэрээний 2.1-д заасан ажлын байран дээр ажиллах ажилтны нэрс, тоо, цалин хөлс олгох журмын талаарх мэдээллийг Гэрээний Хавсралтаар батална.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 3.1. Гэрээний хугацаа: Хөдөлмөрийн тухай хуулийн 50.1.5, 76.2 дугаар зүйлд тус тус зааснаар 1 жилийн хугацаатай байна.

ДӨРӨВ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС БА ЗАРДАЛ

- 4.1. Талууд Үйлчилгээний хөлсийг нэг сараар тооцох ба нийт ажилтны сарын үйлчилгээний хөлс болон НӨАТ-ын нийлбэр нь Захиалагчийн сар бүр төлөх үйлчилгээний хөлс байна. Гэрээний Хавсралт №1-р ажилтан тус бүрийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтооно.
- 4.2. Талууд тухайн сарын үйлчилгээний төлбөрийн тооцоо буюу ажилласан ажилчдын цагийн бүртгэлээр олгох цалин болон урамшууллыг /НДШ-ийн хамт/ бодож тухайн сарын 25-ны өдөр хийж, Захиалагч үйлчилгээний хөлсийг тухайн сарын 30-ны өдрийн дотор төлнө.
- 4.3. Үйлчилгээний хөлсийг Гүйцэтгэгчээс ирүүлсэн нэхэмжлэхийн дагуу Гүйцэтгэгчийн Худалдаа Хөгжлийн Банкны 471020558 тоот харилцах данс руу шилжүүлэн төлнө.
- 4.4. Захиалагч Гүйцэтгэгчийн ажилтнуудыг ажил үйлчилгээ үзүүлэх хугацаанд байрлах байр, хоол, хөдөлмөр хамгааллын багаж хэрэгсэл, ажлын хувцас, гутал, тоног төхөөрөмж, уурхайн эмнэлгийн тоног төхөөрөмж, ажлын шаардлагатай багаж хэрэгсэлээр бүрэн хангана.

ТАВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1. Гүйцэтгэгчээс энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор, цаг хугацаандаа үр дүнтэй биелүүлэх, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг мөрдөн, хөдөлмөрийн сахилга батыг чанд сахин ажиллахыг шаардах эрхтэй.
- 5.2. Гүйцэтгэгчээс гэрээний 2.1-т заасан ажиллах хүчийг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэхийг шаардах эрхтэй.
- 5.3. Гэрээгээр ажиллаж буй ажилтан өөрийн санаачилгаар эсхүл ноцтой зөрчил гаргасны улмаас гэрээг цуцлах, гэрээнээс татгалзах тохиолдолд яаралтай 3 өдрийн дотор зохих мэргэжил, ур чадварын шаардлага хангасан өөр ажилтныг нийлүүлэхийг гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.
- 5.4. Гүйцэтгэгч нь Гэрээний 5.3-т заасан үүргийг тогтоосон хугацаанд гүйцэтгээгүйгээс захиалагчид учирсан хохирлыг гүйцэтгэгч тал үл маргах журмаар хариуцна.
- 5.5. Гэрээгээр ажиллаж буй ажилтнуудад байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг танилцуулах үүрэгтэй.
- 5.6. Гэрээт ажилтнуудад хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны дүрэм, журмын талаарх зааварчилгааг бүрэн өгч, ажиллах хугацаандаа дүрэм журмыг мөрдөж ажиллуулахыг гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.
- 5.7. Гүйцэтгэгчээс нийлүүлсэн гэрээт ажилтан нь компанийн хөдөлмөрийн дотоод дүрэм, журмыг зөрчсөнөөс үүссэн хохирлыг гүйцэтгэгч тал болон буруутай этгээд бүрэн хариуцна.
- 5.8. Гүйцэтгэгчээс нийлүүлсэн гэрээт ажилтан нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажил таслах, ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аюулгүй ажиллагааны стандарттай танилцаж гарын үсэг зураагүй, дүрэм журмыг мөрдөөгүй эсхүл зохих ёсоор мөрдөөгүй, ажлын байран дээр ёс зүйгүй үйлдэл гаргасныг

гэрээний ноцтой зөрчил гаргасанд тооцож гэрээг цуцлах үндэслэл болох бөгөөд үүнээс учирсан хохирол, үр дагаврыг гүйцэтгэгч компани бүрэн хариуцна.

- 5.9. Гэрээний үүргээ зохих ёсоор ямарваа нэгэн сул зогсолт гаргахгүй, ажлын бүтээмж сайтай гүйцэтгэхийг шаардах эрхтэй.
- 5.10. Гэрээт ажилтан гэрээгээр хүлээсэн үүргээ муу, дутуу гүйцэтгэх тохиолдолд гүйцэтгэгч компанид мэдэгдэж, сахилгын шийтгэл оногдуулж болно.
- 5.11. Ажил гүйцэтгэгчийг үүргээ биелүүлэхэд шаардагдах орчин нөхцөл, мэдээллээр хангах үүрэгтэй;
- 5.12. Захиалагч үйлчилгээний хөлсийг энэхүү гэрээний 4.2-т заасан хугацаанд бүрэн төлөх үүрэгтэй.

ЗУРГАА. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 6.1. Энэ гэрээний нөхцөл болон Захиалагчийн дотоод дүрэм журам, ажлын зохион байгуулалт, цагийн хуваарийн дагуу ажилтнаа ажиллуулах үүрэгтэй.
- 6.2. Захиалагчид нийлүүлж буй өөрийн гэрээт ажилтнуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аюулгүй ажиллагааны дүрэм журмын талаарх зааварчилгааг бүрэн өгч, сургалтад хамруулах бөгөөд өдөр тутмын үйл ажиллагаанд нь дүрэм журмыг мөрдүүлж, хяналт тавих үүрэгтэй.
- 6.3. Гэрээний 6.2-т заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйгээс шалтгаалах бүхий л хохирлыг гүйцэтгэгч компани хариуцах үүрэгтэй.
- 6.4. Гэрээт ажилтан захиалагч компанийн дотоод дүрэм, журмыг зохих ёсоор мөрдөөгүйгээс учирсан хохирлыг бүрэн хариуцах үүрэгтэй.
- 6.5. Захиалагчийг энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор, хугацаандаа гүйцэтгэхийг шаардах эрхтэй.
- 6.6. Захиалагчид нийлүүлсэн Ажилтны бүрдүүлсэн баримтын үнэн зөвийг хариуцах үүрэг хүлээх бөгөөд үүнтэй холбоотой учирсан хохирлыг хариуцан арилгах үүрэгтэй.
- 6.7. Ажлын гүйцэтгэлийг зохих ёсоор, тохиролцсон шаардлагад нийцүүлэн ажиллаж байгаа тохиолдолд гэрээгээр тохирсон ажилчдын цалин хөлс төлөхийг шаардах эрхтэй.
- 6.8. Гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд, сул зогсолт гаргахгүй, бүтээмжтэй ажил үүргээ гүйцэтгэх, энэхүү заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой зохих шаардлагыг өөрийн ажилтандаа тавих, хяналт шалгалт хийх үүрэгтэй.
- 6.9. Гэрээт ажилтан нь өвдөж, гэмтэх болон бусад шалтгаанаар цаашид ажиллах боломжгүй болсон үед аль болох түргэн хугацаанд буюу 3 өдрийн дотор оронд нь ажиллах өөр ажилтан ирүүлэх үүрэгтэй.
- 6.10. Гүйцэтгэгч ажилтнуудынхаа сахилга бат, ёс зүйн асуудлыг бүрэн хариуцах ба үүнтэй холбоотой Захиалагчийн зүй ёсны шаардлагыг биелүүлнэ.
- 6.11. Гэрээт ажилтан нь ноцтой зөрчил гаргаж гэрээ цуцлагдвал 5 хоногийн дотор шаардлага хангасан өөр ажилтныг ирүүлнэ.
- 6.12. Гэрээт ажилтан нь захиалагчийн итгэмжлэн хариуцуулсан эд хөрөнгийг эвдэж, гэмтээх, аливаа хохирол учруулсан тохиолдолд түүнийг хариуцан арилгах үүрэгтэй.

ДОЛОО. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮНГ ХҮЛЭЭЛЦЭН БАТАЛГААЖУУЛАХ

- 7.1. Захиалагчийн хэсэг нэгжийн удирдлага 5 өдөр Гүйцэтгэгчийн ажилтны ажлын үр дүн, ирц, ажилласан цагийг бүртгэн баталгаажуулна.
- 7.2. Сарын ажлын нэгтгэсэн тайланд Захиалагчийн эрх бүхий ажилтан, Гүйцэтгэгчийн эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж баталгаажуулна.

НАЙМ. ХАРИУЦЛАГА

- 8.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ цаг хугацаанд нь зохих ёсоор гүйцэтгээгүй, зөрчсөнөөс нөгөө талдаа хохирол учруулсан гэм буруутай тал нь Иргэний хуульд заасан үндэслэл, журмын дагуу хохирлыг арилгах үүрэгтэй.
- 8.2. Гүйцэтгэгчийн ажилтан ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ Захиалагчийн эд хөрөнгө болон гуравдагч этгээдийн эд хөрөнгө, амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан тохиолдолд Гүйцэтгэгч хохирлыг үл маргах журмаар хариуцан арилгах үүрэгтэй.

ЕС. ГЭРЭЭ ЦУЦЛАХ

- 9.1. **Захиалагч цуцлах:** Захиалагч дараах үндэслэлээр гүйцэтгэгчид бичгээр мэдэгдэл өгч энэхүү Гэрээг цуцалж болно. Үүнд:
- 9.1.1. Гүйцэтгэгч нь энэхүү Гэрээний 5.8-д заасан ноцтой зөрчил гаргасан;
 - 9.1.2. Гүйцэтгэгчийн ажил үйлчилгээ хангалтгүй, мэргэжлийн бус гүйцэтгэсэн ба энэхүү доголдоо арилгахыг Захиалагчаас шаардсан хугацаанд биелүүлээгүй;
 - 9.1.3. Гэрээний 11.5 дахь хэсэгт гаргасан баталгаа, мэдэгдэл зөрчигдсөн эсхүл анхнаасаа худал байсан нь тогтоогдсон;
 - 9.1.4. Захиалагч компанийн эзэмшиж буй МУ-021417 тусгай зөвшөөрөл цуцлагдах;
- 9.2. **Гүйцэтгэгч цуцлах:** Гүйцэтгэгч дараах үндэслэлээр Захиалагчид бичгээр мэдэгдэл өгч Гэрээг цуцалж болно. Үүнд:
- 9.2.1. Хэрэв энэ гэрээний дагуу Гүйцэтгэгчид төлөгдөх ёстой төлбөр нэхэмжлэхийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор үйлчилгээний хөлсийг төлөөгүй бол;
- 9.3. Гэрээ цуцлагдсан тохиолдолд Талууд хооронд үүссэн төлбөрийн тооцоог хийж акт үйлдэнэ.
- 9.4. Захиалагч болон Гүйцэтгэгч бичгээр харилцан тохиролцож гэрээг цуцалж болох ба гэрээг ердийн журмаар цуцлах тохиолдолд гэрээг цуцлах тал нөгөө талдаа 21 хоногийн өмнө бичгээр мэдэгдэн, цуцлах бөгөөд мэдэгдээгүйгээс үүдсэн хохирлыг гэм буруутай тал нөхөн төлнө.

АРВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ


- 10.1. Талуудын хооронд энэхүү Гэрээний зүйл, түүнийг тайлбарлах болон түүний хүчин төгөлдөр байдалтай холбоотой аливаа маргаан эсхүл зөрүү үүссэн тохиолдолд талууд уг маргаан, асуудал эсхүл зөрүүний талаар харилцан тохиролцоонд хүрэхийн тулд боломжит бүх хүчин чармайлтыг гаргана. Талууд гучин өдрийн дотор тохиролцоонд хүрч чадаагүй бол аль нэг тал нь нөгөө талдаа бичгээр мэдэгдэл өгч улмаар үүссэн маргааныг Монгол Улсын шүүхээр эцэслэн шийдвэрлүүлнэ.
- 10.2. Ирээдүйд Монгол Улсын шүүхээр Гэрээтэй холбоотой маргааныг шийдвэрлэж, шүүх нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан бол хариуцагч нь нэхэмжлэгчийн, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон бол нэхэмжлэгч нь хариуцагчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулсан зардал, хууль зүйн зөвлөх үйлчилгээний хөлсийг зохих баримтыг үндэслэн бүрэн хариуцан төлнө.

АРВАН НЭГ. БУСАД ЗҮЙЛ

- 11.1. **Нууцлал.** Гэрээ байгуулахтай болон гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой талуудын солилцсон нийтэд ил болоогүй аливаа бичиг баримт, энэхүү гэрээ, ажилчдын мэдээлэл, тайлан, зардлын тооцоо, техникийн өгөгдөл зэрэг аливаа мэдээлэл нь байгууллагын нууц мэдээлэлд хамаарагдах бөгөөд аль нэг талын зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээний аль нэг тал нь гуравдагч талд нууц мэдээллийг задруулахыг хориглоно.

- 11.2. Нууц хадгалах үүргээ зөрчсөн Тал нь үүрэг зөрчигдсөний улмаас нөгөө Талдаа учирсан хохирлыг бүрэн харнуцан төлөх үүрэгтэй.
- 11.3. Талуудын аль нэг нь нөгөө талын зөвшөөрөлгүйгээр гэрээний үйл ажиллагаатай холбоотой хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд ярилцлага, мэдээлэл өгөхгүй байх үүрэгтэй.
- 11.4. **Хүчин төгөлдөр байх.** Гэрээний аль нэг зүйл заалт нь холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрээр хүчингүй эсхүл хэрэгжих боломжгүй болсон нь хүчингүй болсон зүйл заалтаас бусад зүйл, заалт болон гэрээний хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй.
- 11.5. **Мэдэгдэл ба баталгаа.** Гүйцэтгэгч компани нь ажиллах хүч нийлүүлэх үйлчилгээ үзүүлэх бүрэн эрхтэй байна.
- 11.6. Гэрээт ажилтнуудын гаргасан баримт бичгийн бүрдүүлбэр нь хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор олгогдсон үнэн, зөв байна.
- 11.7. Захиалагч нь хуулиар хориглоогүй ажлыг гүйцэтгүүлнэ.
- 11.8. **Хувь.** Энэхүү гэрээг хоёр хувь үйлдсэн ба хувь тус бүрийг эх хувь гэж үзнэ.
- 11.9. **Хавсралтууд.** Гэрээний хавсралтууд нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 11.10. **Нэмэлт өөрчлөлт.** Энэхүү гэрээ болон гэрээнд заасан аливаа баримт бичигт талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба ийнхүү хийгдсэн нэмэлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.
- 11.11. **Заавал дагаж мөрдөх.** Энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар талууд ба тэдгээрийн тус тусын эрх шилжүүлэн авагч нар заавал дагаж мөрдөх үүргийг хүлээнэ.
- 11.12. **Эрх шилжүүлэх.** Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний дагуу хүлээх аливаа эрх, үүргийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр шилжүүлэхийг хориглоно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагчийг төлөөлж:
“Монголиан токен майнинг инвестмент групп корпорэйшн” ХХК

Овог, нэр: Э.ХОНГОРТУЯА
Албан тушаал: Гүйцэтгэх захирал, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч
Утас: 9069-4943

Гүйцэтгэгчийг төлөөлж:
“Монгол тунжен майнинг инвестмент групп” ХХК

Овог, нэр: LUO WEI
Албан тушаал: Гүйцэтгэх захирал, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч
Утас: 9999-9219



БОДЬ ДААТГАЛ
ЭРСДЭЛНИЙ ДАВАХ ҮҮГ

Төв орон, Хамгааллын гудамж 5,
Улаанбаатар хот, Монгол улс
Утас: +976 7504830
E-mail: bod@body-daatgal.com

АЖИЛ ОЛГОГЧИЙН ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛЫН ГЭРЭЭ
№.L1A04C24000164

Гэрээний бүрэлдэхүүн хэсэг:

- I. Үндсэн зөвшөөр
- II. Даатгалын ерөнхий нөхцөл
- III. Даатгалын тэнгэлдлийн үед явах арга хэмжээ
- IV. Гэрээний хяаралт, буцаа хяаралт хяарилтууд багтана.

Батламт:



"МОНГОЛ ТУВИСХОН МАЙНИНГ"
ИНВЕСТМЕНТ Г-ҮҮНГ ХХК
Гүйцэтгэх зөвлөл

ЛУУС ДАН





12. Нөөц ашигласны төлбөр тушаасан баримт
Оны эцсийн тайлангаар бтгалгаажиж гарна.

13. Нөөцийн хөдөлгөөний тайлангийн хуулбар
Оны эцсийн тайлангаар бтгалгаажиж гарна.

14. Хилээр экспортод гаргасан бүтээгдэхүүний талаар гаалийн албанаас гаргасан мэдээ

15. Ус ашиглах дүгнэлт, ус ашиглах гэрээ, төлбөр баримт

Худалдаа Хөгжлийн Банк

Огноо: 2024.11.05 10:48:35

Шилжүүлгийн мэдээлэл

Журналын №: 184297325

Системийн огноо: 2024.08.29

Нэр: МОНГОЛИАН ТОКЕН МАЙНИНГ ИНВЕСТМЕНТ ГРУПП КОРПОРАЙШН ХХК

Илгээгч	Дансны дугаар: 821010565	Нэр МОНГОЛИАН ТОКЕН МАЙНИНГ ИНВЕСТМЕНТ ГРУПП КОРПОРАЙШН ХХК	Дун 5,478,890.00 MNT	Ханш 1.00
/ таван сая дөрвөн зуун далан найман мянга найман зуун ерэн төгрөг /				
Хүлээн авагч	Банкны дугаар: 90 Дансны дугаар 100190000944	Банкны нэр Төрийн сан Нэр Да.Ус ашигласны төлбөр	5,478,890.00 MNT	1.00

Гүйлгээний утга:

EB -рд6438776, МонголТокенМайнингИнвестментГрупп 2024-Ус ашиглах төлбөр-50хувь

Танд баярлалаа

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан

Салбар, тооцооны төв:

Гарын үсэг:

Тамга:

Огноо: ____ Он ____ Сар ____ Өдөр



ХАРАА-ЕРӨӨ ГОЛЫН
САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/42

Дархан

УС АШИГЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 117 дугаар ус ашиглуулах дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт байрлах MV-021417 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, Шарын голын хойд дэнж дээр байрлах "Санжит" алтны шороон ордоос ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаа явуулж буй "Монголиан токен майнинг инвестмент групп корпорэйшн" ХХК-нд, 2024 онд ашиг олох зориулалтаар үйлдвэрлэл үйлчилгээнд ашиглах – 227.2 м³/жил, ашигт малтмал олборлон баяжуулахад – 14'112.0 м³/жил, уурхайн зам талбайн тоосжилт дарах – 1'620.0 м³/жил, шавхан зайлуулах – 18'799.2 м³/жил, ногоон байгууламжийн усалгаанд 225.0 м³/жил, нөхөн сэргээлт хийхэд шаардагдах – 910.8 м³/жил, **НИЙТ-17'145.0 м³/жил** усыг Хараа голын сав газраас авч ашиглахыг зөвшөөрсүгэй.

2. Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1-д заасныг үндэслэн ус ашиглах гэрээ байгуулан, энэ хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 28 дугаар зүйлийн 28.18, 29 дүгээр зүйлийн 29.1, 30 дугаар зүйлийн 30.1, 31 дүгээр зүйлийн 31.1, 31.2 дахь заалт болон ус ашиглахад тавигдах шаардлага, эрх үүргийг мөрдөж ажиллах, Улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдуулан, ус ашиглалтын тайланг тухайн онд багтаан Хараа-Ерөө голын сав газрын захиргаанд ирүүлэн, гэрээг дүгнүүлэхийг "Монголиан токен майнинг инвестмент групп корпорэйшн" ХХК-ний гүйцэтгэх захирлын итгэмжлэгдсэн төлөөлөгч (Э.Хонгортуяа)-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилт болон уурхайн технологийн ус ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Дархан-Уул аймгийн Хонгор сумын Засаг дарга, Байгаль орчны хяналтын Улсын байцаагч, Байгаль хамгаалагч нарт зөвлөсүгэй.

Хавсралт... хуудастай.

ДАРГА



Ө.АРИУНБААТАР

My doc: A/Tushaaf



УС АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ

2024 оны 08 сарын 26 –ны өдөр

Дугаар № 017

Дархан-Уул аймаг

Нэг. Ерөнхий зүйл

Монгол улсын "Усны тухай хууль"-ийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "Усны газар" -ын 2024 оны 08 дугаар сарын 16-ний өдрийн дугаар-117 тоот ус ашиглуулах дүгнэлт, Хараа-Ерөө голын сав газрын захиргаанаас олгосон 2024 оны 08 дугаар сарын 26-ний өдрийн А/42 тоот ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Усны нөөц ашиглуулагчийг төлөөлж Хараа-Ерөө голын сав газрын захиргааны Газарзүй мэдээллийн сан, усны мэдээллийн дэд сан хариуцсан мэргэжилтэн Л.Насанзул, Ус ашиглагчийг төлөөлж Дархан-Уул аймаг Хонгор сум, Шарын голын хойд дэнж, Санжит нэртэй газарт орших 157.08 га талбай бүхий МУ-021417 тоот тусгай зөвшөөрөлтэй, 9911482092 тоот улсын бүртгэлийн, 6438776 тоот регистрийн дугаартай "Санжит" алтны шороон ордыг ил аргаар олборлох "Монголиан токен майнинг инвестмент групп корпорэйшн" ХХК-ийн гүйцэтгэх захирлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Э.Хонгортуяа нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 4 сарын хугацаатайгаар байгуулав. Усны газрын ус ашиглуулах дүгнэлтээр 84 хоног ажиллахаар тооцоо гаргасан.

1.2. Гэрээг Монгол хэлээр 3% үйлдэж талуудад нэг нэг хувь хадгалагдах бөгөөд аль ч хувь нь хуулийн хүчинтэй баримт мөн.

1.3. Энэхүү гэрээнд тусгагдаагүй зүйлийг Монгол Улсын холбогдох хуулиар зохицуулна.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт: Баяжуулах технологид болон, зам талбайн усалгаа, мод тарих хэрэгцээнд. Уурхайд 22 хүн, 2 ээлж, 20 цагаар 84 хоног ажиллана.

2.2. Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 тоот тушаалаар баталсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны хэрэглээний норм"-ын дагуу үйлдвэрлэлийн хэрэгцээний усны хэмжээг тооцоход:

Техникийн хүчин чадлаар үйлдвэрлэл болон бусад үйл ажиллагаанд шаардагдах усны хэмжээг тооцвол:

$70,560.0 \text{ м}^3 * 0.2 = 14,112.0 \text{ м}^3$ – Ашигт малтмал баяжуулахад шаардагдах усны хэмжээ.

$223.8 \text{ м}^3 * 84 = 18,799.2 \text{ м}^3$ – Уурхайн ухлагаас шавхан зайлуулах умны хэмжээ.

$500 \text{ ширхэг} * 50 \text{ л/ш} * 9 \text{ удаа} = 225.0 \text{ м}^3$ – Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модонд ашиглах усны хэмжээ.

$13,500 \text{ м}^2 * 2.0 \text{ л/м}^2 * 60 \text{ хон} = 1,620.0 \text{ м}^3$ –Зам талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ

$22 \text{ хүн} * 150.0 \text{ л/хон} * 84 \text{ хон} = 277.2 \text{ м}^3$ – Ашиг олох зориулалтаар ахуйд ашиглах усны хэмжээ.

$25,300 \text{ м}^2 * 4\text{л} * 9 \text{ удаа} = 910.8 \text{ м}^3$ – Биологийн нөхөн сэргээлт (шимт хөрс)-0.03га, биологийн нөхөн сэргээлт-1 га, дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтэд зарцуулах усны хэмжээ.

Нийт ашиглах усны хэмжээ: $14,112.0 \text{ м}^3 + 1,620.0 \text{ м}^3 + 225.0 \text{ м}^3 + 277.2 \text{ м}^3 + 910.8 \text{ м}^3 = 17,145.0 \text{ м}^3$

2.3. Усны чанар, найрлага: Шинжилгээгээр гидрокарбонат-кальций-натрийн химийн найрлагатай гэж тогтоогдсон учир ундны усны шаардлага хангадаг.

2.4. Усны эх үүсвэрийн байршил, хоногт ашиглах усны хэмжээ: Ордын нөөцийн гол хэсэгт өмнөх ашиглалтын явцад гарсан нуур цөөрөм, мөн ордоос зүүн урд 230 метрийн зайд байрлах ухмал карьерт хуримтлагдсан усыг үйлдвэрлэлд ашиглана. Шаардагдах усны 80 %-ийг технологийн эргэлтийн усаар, 20 %-ийг цэвэр усаар хангана.

2.5. Усны барилга байгууламж:

Ус шүүрэлтийг багасгах шавран хамгаалалтын бүрхүүлтэй, усны түвшинг далангийн дээд ирмэгээс 2 метр байхаар урт нь 50 метр, өргөн нь 60 метр. Хаягдлын далад технологийн усыг тунгааж шүүрүүлэх бөгөөд тунасан ус өөрийн урсгалаар эргэлтийн усан санд цуглана.

2.6. Худаг өргөлтийн станцууд усны тоолуур насосны хүчин чадал: Баяжуулах үйлдвэрийн усан хангамжийн худгийн байршил

2.7. Дамжуулах байгууламж:

2.8. Хаягдал усны хэмжээ цэвэрлэгээний арга:

Унд ахуйн хэрэгцээнээс гарсан бохир усыг хөрсөнд нэвчүүлнэ.

2.9. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл:

"Монголиан Токен майнинг инвестмент групп корпорэйшн" ХХК-ийн "Санжит" алтны шороон ордыг ашиглах төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг 2024 онд "Салблейм" ХХК хийж гүйцэтгэсэн.

2.10 Онцгой нөхцөл:

- Улирал бүр 2-с доошгүй удаа хаягдал усны холимог сорьц авч байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж дүнг улирал бүр сав газрын захиргаанд ирүүлэх.

- Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А82/128 тоот хамтарсан тушаалаар батлагдсан ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журмыг хэрэгжүүлэн ажиллах.

2.11. Ус ашигласны төлбөрийн хэмжээ:

Уурхайн ухлагаас шавхан зайлуулж технологи болон бусад хэрэглээнд ашиглах **18,799.2 м³ /жил**, ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл үйлчилгээнд ашиглах **277.2 м³/жил** газрын доорх усны төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолд заасан суурь үнэлгээ, 2013 оны 326, 327 дугаар тогтоолд заасан усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ, ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүрийг тус тус үндэслэн урьдчилсан байдлаар тооцвол:

Уурхайн ухлагаас газрын доорх ус шавхан зайлуулсны төлбөр:

1 м³ газрын доорх усны үнэ: 2,764.0 төг x 0.15 x 1.4 = 580.44 төг

2,764 төг/м³: Засгийн газрын 2011 оны 302-р тогтоолоор Хараа-Ерөө голын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;

15%: Засгийн газрын 2013 оны 326-р тогтоолын 7.в-д заасан газрын доорх ус ашигласныг тооцох хувь, хэмжээ;

1.4: Засгийн газрын 2013 оны 327-р тогтоолд заасан Хараа-Ерөө голын сав газарт газрын доорх ус шавхан зайлуулахад тооцох итгэлцүүр.

18,799.2 м³ x 580.44 төг/м³ = 10,911,807.7 төг

Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл үйлчилгээнд ашиглах усны төлбөр:

1 м³ газрын доорх усны үнэ: 2,764 төг/м³ x 0.15 x 0.4 = 165.84 төг/м³

2,764 төг/м³: Засгийн газрын 2011 оны 302-р тогтоолоор Хараа-Ерөө голын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи-эдийн засгийн суурь үнэ;

15%: Засгийн газрын 2013 оны 326-р тогтоолын 10-т заасан ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл үйлчилгээнд газрын доорх ус ашигласныг тооцох төлбөрийн хувь, хэмжээ;

0.4: Засгийн газрын 2013 оны 327-р тогтоолд ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл үйлчилгээнд Хараа-Ерөө голын сав газарт газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр.

$277.2 \text{ м}^3/\text{жил} \times 165.84 \text{ төг} = 45,970.85 \text{ төг}$

Нийт төлбөр: 10,911,807.7 төг + 45,970.85 төг = 10,957,778.55 төг

(Арван сая есөн зуун тавин долоон мянга долоон зуун далан найман төгрөг тавин таван мөнгө)

Төлбөр төлөлт: Усны нөөц ашигласны төлбөрийг Дархан-Уул аймгийн төрийн сан банкны 100190000944 тоот дансанд 2024 оны 09 дүгээр сарын 20-ний өдөр нийт төлбөрийн 50 хувь, 2024 оны 11 сарын 15-ний өдрийн дотор үлдэгдэл төлбөрийг төлж барагдуулна.

Ус ашиглалтын мэдээ тайлан, болон усны нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төлсөн (хагас, бүтэн жилээр төвлөрүүлж) тайланг Хараа-Ерөө голын сав газрын захиргаанд гаргаж өгнө.

Засгийн газрын 2018 оны 391 тоот тогтоолоор батлагдсан "Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журмын дагуу илүү ашигласан усны төлбөрийг илүү ашигласан усны эзлэх хувийн жингээр шатлан өсгөж төлөхөөр заасныг анхаарч, жил бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөө, календарьчилсан графикайг үндэслэлтэй, үнэн зөв гаргаж байх.

Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1 Гэрээ байгуулагч талууд нь "Усны тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 22 дугаар зүйл, 24 дүгээр зүйл, 28 дугаар зүйл, 29 дүгээр зүйл 30 дугаар зүйлийн 30.1.2, 30.2, 31 дүгээр зүйлийн 31.2, 31.1.1 –д заасан зүйл заалтуудын дагуу эрх эдэлж үүрэг хүлээнэ.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг, дарж баталгаажсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний биелэлтийг талууд 2024 оны 12-р сарын 01-ний өдрийн дотор ус ашиглалтын тайлан болон усны нөөц ашигласны төлбөрийн мэдээг хүлээн авч гэрээний биелэлтийг дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцооноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9, 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалтууд болон дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцална.

4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн.

4.5.2. Аль нэг тал нь татан буугдсан.

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД:

Ус ашиглуулагчийг төлөөлж:

ХЕГСГЗ-ны Газарзүй мэдээллийн сан,
усны мэдээллийн дэд сан хариуцсан
мэргэжилтэн

..... Л.Насанзул

Ус ашиглагчийг төлөөлж:

"Монголиан токен майнинг инвестмент"
групп корпорейшн" ХХК-ийн Геологийн
инженер

..... Х.Бат-Эрдэнэ

ХАЯГ:

Дархан-Уул аймаг, Дархан сум, 14 баг,
Монгол банкны 3 давхар, 301 тоот
Хараа-Ерөө голын сав газрын захиргаа
Утас: 70373171

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө
гудамж, Эко интернэйшл тауэр, 15
давхар. Утас: 77189988

БАТЛАВ:
"ДУЛААН ШАРЫН ГОЛ"
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТ ЭХ
ЗАХИРАЛ



П. БАЯРЦЭЦЭГ

БАТЛАВ:
"МОНГОЛИАН ТОХЕН МАЙНИНГ"
ИНВЕСТМЕНТ ГРУПП КОРПОРАЙШН"
ХХК-ИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ
ТӨСЛИЙН ЗАХИРАЛ



Ч. ОРГИЛ

ЦЭВЭР УСААР ХАНГАХ ГЭРЭЭ

2023 оны 9-р сарын 12-ны өдөр

Дугаар *100/20*

Шарын гол сум

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү Гэрээг Усны тухай, Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийг үндэслэн нэг талаас "Дулаан Шарын гол" ТӨХК, түүнийг төлөөлж Санхүү борлуулалтын хэлтсийн борлуулалтын мэргэжилтэн Э.Мөнгөнчимэг (цаашид "Хангагч" гэх), нөгөө талаас "Монголиан токен майнинг инвестмент групп корпорэйшн" ХХК, түүнийг төлөөлж Байгаль орчны мэргэжилтэн /албан тушаал/ ажилтан А.Галтбаатар (цаашид "Хэрэглэгч" хамтад нь "Талууд" гэх) нар 2023 оны 9 дүгээр сарын 11 ний өдрөөс 2024 оны 8 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд цэвэр усаар хангахаар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1.2. Энэхүү гэрээгээр хэрэглэгчийн хэрэгцээнд шаардлагатай цэвэр ус нийлүүлэх, цэвэр усны төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх талуудын хоорондын харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. ТАЛУУДЫН ЭРХ ҮҮРЭГ

2.1. Хэрэглэгчийн эрх, үүрэг

- 2.1.1. Стандартын шаардлага хангасан цэвэр усаар хангахыг хангагчаас шаардах эрхтэй.
- 2.1.2. Хэрэглэгч дулаан дамжуулах төвийн дэргэдэх цэвэр ус түгээх цэгээс усаа авах ба хангагчийн эрх бүхий ажилтныг байлцуулан авч акт үйлдэнэ.
- 2.1.3. Цэвэр усны төлбөрийг төлөх эрх бүхий албан тушаалтанаас зөвшөөрөл авсаны дараа усаа авч байх үүрэгтэй.
- 2.1.4. Цэвэр ус авахдаа хангагчийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг гэмтэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах үүрэгтэй.
- 2.1.5. Цэвэр ус зөөвөрлөх, хадгалах асуудлыг хэрэглэгч өөрөө хариуцна.
- 2.1.6. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

2.2. Хангагчийн эрх, үүрэг

- 2.2.1. Хэрэглэгчийн хэрэгцээнд шаардлагатай зохих стандартад нийцсэн цэвэр усаар хангах үүрэгтэй.
- 2.2.2. Цэвэр усаар хангасны төлбөрийг хугацаандаа төлөхийг хэрэглэгчээс шаардах эрхтэй.
- 2.2.3. Цэвэр ус зөөвөрлөх автомашин нь аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байхыг хэрэглэгчээс шаардах эрхтэй. Ус зөөвөрлөх автомашины ёмжост болон ус хадгалах саванд ариутгал, халдваргүйжилт хийгдсэн байхыг хэрэглэгчээс шаардана.
- 2.2.4. Ус зөөвөрлөх автомашины ёмжост, ус хадгалах саванд ариутгал, халдваргүйжилтийг зохих стандартын дагуу бүрэн хийгээгүйгээс усны чанар, эрүүл ахуй, найрлагад өөрчлөлт орсноос үүдэн бий болсон аливаа хохирлыг хангагч тал хариуцахгүй.
- 2.2.5. Хэрэглэгч цэвэр ус зөөвөрлөх автомашиныхаа ёмжост, ус хадгалах саванд өөрөө хариуцан ариутгана. Хэрэв ус зөөвөрлөх автомашины ёмжост, ус хадгалах саванд

хангагчаар ариутгуулахаар бол албан бичгээр хандаж, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

2.2.6. Хэрэглэгчид цэвэр усаар хангах үйл ажиллагаатай холбоотой мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч болно.

2.2.7. Хууль тогтоомьд заасан бусад арг, үүрэг.

ГУРАВ. ТӨЛБӨР ТООЦОО

3.1. Цэвэр усны төлбөрийг Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн тогтоосон тарифаар тооцно. 1/нэг/ литр усыг 10/арав/ төгрөгөөр тооцож бодно.

3.2. Хэрэглэгч цэвэр усны хэрэглээний жилийн захиалгыг хэвсгалтын дагуу сар бүрээр гаргаж, захиалгын дагуу төлбөрийг урьдчилж гэрээ байгуулсан өдөр хангагч байгууллагын хэссанд бэлнээр аль эсвэл ХААН Банкны 5047090007 тоот дансанд тушаана.

3.3. Цэвэр ус зөөвөрлөх автомашины багтаамжаар хэрэглэгчийн авсан цэвэр усны хэмжээг тооцно.

3.4. Хэрэв төлбөрийг төлөөгүй тохиолдолд цэвэр усаар хангахгүй.

ДӨРӨВ. ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

4.1. Хэрэглэгч нь цэвэр усны шугам сүлжээнээс хангагчийн зохих зөвшөөрөлгүйгээр цэвэр ус авсан, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг гэмтээсэн тохиолдолд хангагчид учирсан хохирлыг бүрэн барагдуулна.

4.2. Талуудын аль нэг тал үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал үүргээ биелүүлэх тодорхой хугацаа зааж шаардлага тавих бөгөөд авсан хугацаанд үүргээ биелүүлээгүй нөхцөлд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авч болно.

ТАВ. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

5.1. Энэхүү гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэхийг эрхэмлэх ба тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд зохих хууль, тогтоомжийн дагуу маргаантай асуудлыг Монгол Улсын Шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

6.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж баталгаажуулсан адрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

6.2. Талууд харилцан тохиролцоож энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох ба нэмэлт өөрчлөлт нь бичгээр үйлдэгдэн талууд гарын үсэг зурж, тамга даран уг гэрээнд нэмэлтээр хавсаргагдана.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Талууд энэхүү гэрээнд заасан бүхий л нөхцөл заалтуудыг хүлээн зөвшөөрч байгаагаа нотлон доор гарын үсэг зурж баталгаажуулав.

ХАНГАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"ДУЛААН ШАРЫН ГОЛ" ТӨХК-ийн
СБХ-ийн Борлуулалтын мэргэжилтэн

 З. Мөнгөнчимэг
Утас: 99147071

ХЭРЭГЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


"МОНГОЛИАН ТОКЕН МАЙНИНГ"
ИНВЕСТМЕНТ ГРУПП КОРПОРАЙШН"
ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн

 А. Галтбаатар
Утас: 99143773

2023 оны 9 сарын 12 –ны
өдрийн ... тоот гарааний
хавсралт

"Монголиан токен майнинг инвестмент групп корпорэйшн" ХХК-ийн 2023 оны
ус ашиглах хуваарь

д/д	Сар	Усны хэрэглээ /литр/	Нагж үнэ	Үнэ
1	9 сар	2000	10	20000
2	10 сар	2000	10	20000
3	11 сар	2000	10	20000
4	12 сар	2000	10	20000
5	1 сар	2000	10	20000
6	2 сар	2000	10	20000
7	3 сар	20000	10	200000
8	4 сар	20000	10	200000
9	5 сар	20000	10	200000
10	6 сар	20000	10	200000
11	7 сар	20000	10	200000
12	8 сар	20000	10	200000
	НИЙТ ДҮН	24000	10	1320000

Хуваарь гаргасан:
"Монголиан токен майнинг
инвестмент групп корпорэйшн" ХХК-ийн,
Байгаль орчны мөргөжигчэн  /А.Галтбатар/

16. Хог хаягдлын гэрээ, төлбөр баримт

БАТЛАВ: ДАРХАН-УУЛБААТАР
 "Хонгор сумын "Хонгор хот тохижилт"
 ОНӨААТҮГ-аарын дарга /Д.Ариунболд/

БАТЛАВ: ДАРХАН-УУЛБААТАР ХОТ
 Монгол токен майнинг инвестмент групп
 корпорэйшн ХХК-ийн захирал
 /LUO XIAO YONG/

**АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ХОГ ХАЯГДЛЫГ
 ТЭЭВЭРЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ**

2024 оны 03 сарын 26 өдөр

№22...

Буурал

ААНэгж, байгууллагын нэр	"Монгол токен майнинг инвестмент групп корпорэйшн" ХХК	
Регистрийн дугаар	6438776	
Үйл ажиллагааны чиглэл	Уул уурхай	
ААНэгж, Байгууллагын хаяг	Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг 1 дүгээр хороо, 5 дугаар хороолол Энхтайвны өргөн чөлөө гудамж "Эко интернэйшл тауэр" барилгын 15 давхар	
Харилцах утас	99108437	
"Хонгор хот тохижилт" ОНӨААТҮГ-аарын данс	ХААН Банк 5054187159 , РД4293754	
Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төрөл	Сард 180,000	Рейсийн тоогоор 1 рейсийн төгрөг
Гэрээний хугацаа	2024 оны 3 р сарын 26 ны өдрөөс 2024 оны 12 р сарын 31 ны өдөр хүртэл	

Нэг: Гэрээний зорилго

1.1. Монгол Улсын ариун цэврийн тухай, Хог хаягдлын тухай хуулиудыг хэрэгжүүлэх иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдлыг тээвэрлэх, энэ гэрээгээр төлбөр төлөхтэй үүссэн харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хонгор сумын "Хонгор хот тохижилт" ОНӨААТҮГ-аарыг төлөөлж Орлогын байцаагч Г.Нарангуяа /цаашид "тээвэрлэгч" гэх/ нөгөө талаас Байгаль орчны мэргэжилтэн албан тушаалтай Адъяасүрэн овогтой Галтбаатар төлөөлж /цаашид "үйлчлүүлэгч" гэх/ нар харилцан тохирч ИТХ-ын 2023 оны 17-р тогтоолын дагуу дараах нөхцөлүүдээр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Хоёр: Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг.

2.1. Зориулалтын цэгээс бусад газарт хог хаяхгүй байх.

2.2. Өөрийн байгууллагын эргэн тойронд 50 метр зайд тогтмол цэвэрлэгээ хийж, хог хаягдалгүй байлгах.

2.3. Орчин тойрондоо гэрэлтүүлэгтэй байх, гэрлийн шил, бүрхүүл шатсан, хагарсан, алдсан тохиолдолд тухай бүр шинэчлэн сольж байх.

2.4. Багийн Засаг дарга, сумын БОХУБайцаагч, сумын "Хонгор хот тохижилт" -ын ажилтны зүй ёсны шаардлагыг биелүүлэх.

2.5. Өөрийн байгууллага /хашаа/ дахь хогоо төвлөрүүлэн тодорхой цэгт цуглуулах, байхгүй бол сумын төв дэх төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлэх

Гурав: Тээвэрлэгчийн эрх, үүрэг.

3.1. Хог, хаягдлыг цуглуулах, төвлөрсөн цэгт тээвэрлэх, ачиж буулгах ажлыг эрхлэх зохион байгуулах

3.2. Тогтоосон журмын дагуу хог хаягдлыг ачиж, тээвэрлэсний үнийг сар бүр тушаалгах

3.3. Хууль тогтоомж, гэрээний үүргийн биелэлтийн талаар үйлчлүүлэгчид шаардлага тавих,

3.4. Үйлчлүүлэгчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг сар бүр дүгнэж байх

Дөрөв: Хүлээлгэх хариуцлага.

4.1. Зориулалтын бус газар хог хаягдал гаргасан бол Хог хаягдлын тухай хуулийн 23-р зүйлийн 23.1.1-д заасны дагуу иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3-5 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр, ААН Байгууллагыг 5-10 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр торгож, учирсан хохирлыг арилгуулах

4.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож, төлөх үнийн дүнд 0.5 хувиар алданги төлүүлэх

Тав: Нэмэлт заалт .

.....
.....
.....

Зургаа: Гэрээ байгуулсан.

Сумын "Хонгор хот тохижилт"
ОНӨААТҮГазрыг төлөөлж

.....
/Г.Нарантуяа/
Утас : 99372324

* Монгол токен майнинг инвестмент
групп корпорэйшн" ХХК -ийг төлөөлж

.....
/А.Галтбаатар/
Утас: 99143773

Худалдаа Хөгжлийн Банк Огноо: 2024.09.25 17:57:03

Шилжүүлгийн мэдээлэл
Журналын №: 190318670

Системийн огноо: 2024.09.25

Нэр: **МОНГОЛИАН ТОКЕН МАЙНИНГ ИНВЕСТМЕНТ ГРУПП КОРПОРАЙШН ХХК**

Илгээгч	Дансны дугаар: 821010565	Нэр МОНГОЛИАН ТОКЕН МАЙНИНГ ИНВЕСТМЕНТ ГРУПП КОРПОРАЙШН ХХК	Дүн 480,000.00 MNT	Ханш 1.00
/ дөрвөн зуун наян мянган төгрөг /				
Хүлээн авагч	Банкны дугаар: 05 Дансны дугаар: 5054187159	Банкны нэр Хаан Банк Нэр ОТ ТОХИЖИЛТДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН ХОНГОР Х	480,000.00 MNT	1.00

Гүйлгээний утга:
EB -рд6438776 МонголТокенМайнинг Хог хаягдлын үйл/төлбөр

Танд баярлалаа

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан

Салбар, тооцооны төв:

Гарын үсэг:

Тамга:

17. Орон нутагтай хамтран ажиллах гэрээ, дүгнэлт



Гэрээний хүрээнд Хогны авто машин өгсөн



100 хүүхдэд баярын бэлэг

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ, ҮЙЛДВЭР
БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ,
АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ

2024.03.25

№

Буурал

Энэхүү гэрээг нэг талаас Дархан-Уул аймгийн Хонгор сумын Засаг дарга Т.Атархишиг /цаашид "Засаг дарга" гэх/, нөгөө талаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Монголион токен майнинг инвестмент групп корпорэйшн" ХХК /цаашид "Тусгай зөвшөөрөл эзэмшигч" гэх/ нар /цаашид хамтад нь "Талууд" гэх/ дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Дархан-Уул аймаг Хонгор суманд байгуулав.

Нэг: Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээ нь Дархан-Уул аймаг Хонгор сумын нутагт ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрөл бүхий талбай орших аймаг, сумын байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлнэ.

1.3. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй энэхүү гэрээг тухайн аймгийн Засаг даргатай байгуулна.

Хоёр: Засаг даргын эрх, үүрэг

2.1. Энэхүү гэрээний хүрээнд Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

2.1.1. хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрх, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах,

2.1.2. гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч, саналыг нь авах,

2.1.3. энэхүү гэрээний хэрэгжилттэй холбоотой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж аймаг, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан төсөл, арга хэмжээнээс тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг сонгож, түүнтэй зөвшилцсөний үндсэн дээр энэ тухай иргэдэд мэдээлэх,

2.1.4. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр болон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах,

2.1.5. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих

2.1.6. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх

Гурав: Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх үүрэг

3.1. Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1. үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх,

3.1.2. орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай хамтарч ажиллан шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах

3.1.3. хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах,

3.1.4. нийт ажлын байрны 50-иас доошгүй хувьд тухайн орон нутгийн иргэдийг зохих төвшний сургалтад хамруулсны үндсэн дээр ажиллуулах,

3.1.5. өөр орон нутгаас ажилтан, мэргэжилтэн урт хугацаагаар авч ажиллуулах тохиолдолд холбогдох хуулийн дагуу тухайн ажилтныг Засаг даргын Тамгын газарт бүртгүүлэх,

3.1.6. хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар тухайн аймаг, сумын иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч байх,

3.1.7. бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжид давуу эрх олгох,

3.1.8. байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах,

3.1.9. Тусгай зөвшөөрөл эзэмшигч "Монголион токен майнинг инвестмент групп корпорэйшн" ХХК нь жил бүр 20-оос доошгүй ахмадад хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулж байна

3.1.10. Тусгай зөвшөөрөл эзэмшигч "Монголион токен майнинг инвестмент групп корпорэйшн" ХХК нь жил бүр 20-оос доошгүй хүүхдүүдэд хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулж байна

3.1.11. Дархан Уул аймгийн Хонгор суманд нийгмийн хариуцлагын хүрээнд Тусгай зориулалтын хог тээвэрлэх авто машин худалдан авах 50 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар дэмжлэг үзүүлэх

Дөрөв: Хамтын ажиллагааны хороо

4.1. Талуудын гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороо /цаашид хороо гэх/-г Засаг даргын тамгын газар, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулна.

4.2. Хороо нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд талуудын оролцоог тэгш хангасан байна. Хорооны бүрэлдэхүүнд орох иргэдийн төлөөллийг иргэдийн нийтийн хурлаас нэр дэвшүүлнэ. Хорооны бүрэлдэхүүнийг тухайн шатны Засаг дарга томилж, чөлөөлнө.

4.3. Хороо гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

Тав: Гэрээний хэрэгжилт

5.1. Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаарх мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна. Гэрээний хувийг ажлын 5 хоногийн дотор аймаг, сум /дүүргийн/ олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлд хүргүүлнэ.

5.2. Талууд гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тайланг дараа оны 2 дугаар сарын 01-ний дотор аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

5.3. Талууд гэрээний тухайн жилийн биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор дээд шатны Засаг дарга болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

5.4 Гэрээний нийт төлбөр болох 50,0 сая төгрөгийг гэрээ байгуулснаас хойш 55 хоногт багтаан нийлүүлнэ.

5.5 Гэрээ байгуулснаас хойш 55 хоногийн дотор тусгай зориулалтын хог тээвэрлэх авто машин нийлүүлээгүй тохиолдолд гэрээг хүчингүй тооцно.

Зургаа: Гэрээний хариуцлага

6.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсан эсэх талаарх мэдээллийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

Долоо: Маргаан шийдвэрлэх

7.1. Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв дүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

Найм: Гэрээ хүчин төгөлдөр болох

8.1. Талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

8.2. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.

8.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.

8.4. Гэрээг монгол хэл дээр 2 хувь үйлдэнэ. Зайлшгүй тохиолдолд гэрээний хувийг англи хэл дээр үйлдэж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:



Нутгийн захиргааны байгууллагыг төлөөлж:

Дархан-Уул аймгийн Хонгор

сумын Засаг дарга Т.Атархишиг




Нэр, гарын үсэг
Тамга, тэмдэг


Ашигт малтмалын байгууллагыг төлөөлж:

"Монголион токен майнинг инвестмент

групп корпорэйшн" ХХК-ний

захирал Лув'Хиао Yong

Утас: 77189988

Нэр, гарын үсэг
Тамга, тэмдэг